

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 8 дугаар сарын 29-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 - 31

1. *Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./*

4 - 31

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 8 дугаар сарын 29-ний өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 44 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Ариунзаяа, Д.Ганмаа;

Чөлөөтэй: Ц.Баатархүү, Ц.Мөнхтуяа, Б.Түвшин, С.Эрдэнэбат.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогтбадрах, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Энхтөр, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч, ахлах шинжээч Ц.Эрдэнэтөгс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга М.Маргад-Эрдэнэ, Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ихтамир, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Алтанцэцэг, мөн газрын Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, мөн яамны Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Хонгорзул, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын ерөнхий газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор Б.Идэрбалжинням, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Ц.Хосжаргал, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер С.Нацагдорж, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Болор-Эрдэнэ, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор В.Эрдэнэцогт, И.Эрдэнэцэцэг, Б.Эрдэнэзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Илтгэл болон тайланд хийсэн аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, М.Нарантуяа-Нара, Б.Бейсен, Ж.Баярмаа, Ж.Чинбүрэн, Л.Энхнасан нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн дарга Л.Лувсан, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Б.Бейсен, Ж.Баярмаа, Д.Үүрийнтуяа нар үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёрдугаар хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 26 минут үргэлжилж, 21 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 14 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Л.ЭНХНАСАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 8 дугаар сарын 29-ний өдөр, Пүрэв гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
12 цаг 44 минут

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Энхнасан: Өглөөний мэнд.
Гишүүд ээ,

Байнгын хорооны эрхэм гишүүдэд
өдрийн мэнд хүргэе.

Одоо хурал жоохон хоцорлоо.
Хүлцэл өчье.

Байнгын хорооны хуралд оролцож
байгаа гишүүдийг танилцуулъя.

Б.Бат-Эрдэнэ гишүүн,
Ж.Баясгалан гишүүн, Ж.Баярмаа гишүүн,
Б.Бейсен гишүүн, Х.Болормаа гишүүн,
Х.Булгантуяа гишүүн, М.Ганхүлэг
гишүүн, С.Зулпхар гишүүн,
М.Нарантуяа-Нара гишүүн,
Д.Үүрийнтуяа гишүүн, О.Саранчулуун
гишүүн, М.Сарнай гишүүн, Ж.Чинбүрэн
гишүүн. Эдгээр хүмүүс оролцож байна.

Хуралдааны ирцийг танилцуулж
дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны гишүүдийн
олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны
ирц 66.7 хувьтай бүрдсэн тул Байнгын
хорооны 2024 оны 8 дугаар сарын 29-ний
өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.
/алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар
хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Засгийн газрын 2024 оны 8 дугаар
сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн
Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны
гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны
санхүүгийн нэгдсэн тайлан болон
“Монгол Улсын 2023 оны төсвийн
гүйцэтгэл батлах тухай” Улсын Их
Хурлын тогтоолын төсөл. Хоёрдугаар
хэлэлцүүлэг.

Санал, дүгнэлтийг Төсвийн
зарлагын хяналтын дэд хороонд
хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудалтай санал хэлэх
гишүүд байна уу? Саналтай гишүүн
байхгүй юм байна.

Хэлэлцэх асуудалдаа орьё. /алх
цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн
2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023
оны санхүүгийн нэгдсэн тайлан болон
“Монгол Улсын 2023 оны төсвийн
гүйцэтгэл батлах тухай” Улсын Их
Хурлын тогтоолын төслийн хоёр дахь
хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийг оруулна уу.
Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг
танилцуулъя.

Тогтмолын Мөнхсайхан Эрүүл
мэндийн сайд, Дэлэгийн Загджав Монгол
Улсын Ерөнхий аудитор, Жамбалын

Энхтөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Цэвэгдоржийн Эрдэнэтөгс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч, ахлах шинжээч, Зөвөөгийн Энхболд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, Мандалбаатарын Маргад-Эрдэнэ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга, Тогоохүүгийн Ихтамир Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэнд-Аюушийн Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Басангийн Алтанцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга, Б.Даваахүү Нийгмийн даатгалын ерөнхий газрын Захиргаа, удирдлагын газрын дарга, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагважавын Лувсан Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн дарга, Лхагважавын Мөнхцэцэг Эрүүл мэндийн яамны Санхүү, даатгалын хэлтсийн дарга, Т.Хонгорзул Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Шаравнямбуугийн Энхтуяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хянан зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ламжавын Бямбасүрэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Чойжоогийн Гантөмөр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Ц.Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын

газрын захирал, тэргүүлэх аудитор, Ю.Энхтуяа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Б.Идэрбалжинням Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, Ц.Хосжаргал Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, С.Нацагдорж Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Б.Болор-Эрдэнэ Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, В.Эрдэнэцогт Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, И.Эрдэнэцэцэг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Б.Эрдэнэзул Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Бэлтрэгийн Цогтбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга.

Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг Боомтын сэргэлтийн сайд Б.Тулга танилцуулаа.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав дараа нь танилцуулаа.

4 номерын микрофоныг өгнө үү.

Б.Тулга: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн

хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Боловсролын сайдын багц, Эрүүл мэндийн сайдын багц, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багц, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан нийт 450 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 13 их наяд 509.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардалд 12 их наяд 604.6 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 907.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 32 хувь буюу 35.2 тэрбум төгрөгийг Нийгмийн даатгалын сан, 23 хувь буюу 25 тэрбум төгрөгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 21 хувь буюу 23.2 тэрбум төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын зарлага эзэлж байна.

Улсын төсвөөс 109 их наяд 931.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 1.7 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал хандуулсан Та бүхэнд талархлаа.

Л.Энхнасан: Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Уучлаарай. Аудитын дүгнэлтээ сонсчхоод асуултаа асуух юм байна.

Д.Загджав даргын микрофоныг өгнө үү.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

Нэг.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, хуучнаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх

асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 156 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 113 байгууллагад дүгнэлт гаргаж, 43 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн эрхлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай харьяа 86 байгууллагын санхүүгийн тайланд өөрчлөлтгүй, 25 байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай.

Дорнод аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газарт татгалзсан дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 73.5 тэрбум төгрөгийн 352 зөрчил илэрснээс 0.3 тэрбум төгрөгийн 55 зөрчил төлбөрийн акт тогтоож, 9.7 тэрбум төгрөгийн зөрчлийг арилга 102 албан шаардлага хүргүүлж, 40.6 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 188 зөвлөмж өгч, 22.9 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 7 албан шаардлага хүргүүлээ.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 28.4 тэрбум төгрөгийн 185 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийслэлийн асуудлаар нийт 20 тэрбум төгрөгийн 111 зөрчил илэрснээс 0.9 сая төгрөгийн зөрчилд нийт төлбөрийн акт тогтоож, 15.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 40 албан шаардлага хүргүүлж, 4.8 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 68 зөвлөмж өгч, 53.3 сая төгрөгийн зөрчилд 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 33 төсөл, арга хэмжээний 36.8 тэрбум төгрөгийг улсын төсвийн

хөрөнгийн санхүүжилтээр, 2.3 тэрбум төгрөгийн худалдан авалтыг урсгал санхүүжилтээр бэлтгэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын санхүүжилтээс он дамжин хэрэгжих 14 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 22.1 тэрбум төгрөгийг олгож, урсгал зардлын санхүүжилтээс 61 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний харьцуулалтын аргаар, 0.3 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 0.3 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулж, гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож, 95 хувийн хэрэгжилттэй байна.

Хоёр. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 450 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 370 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 79 байгууллагын аудитын түүвэрт хамруулж, 1 байгууллага аудитад хамрагдаагүй.

Аудит дээр төсвийн эрхлэн захирчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 11 байгууллагад өөрчлөлтгүй, 51 байгууллагад хязгаарлалттай, 4 байгууллагад сөрөг дүгнэлт өгч, 4 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 83.1 тэрбум төгрөгийн 1082 зөрчил илэрснээс 0.6 тэрбум төгрөгийн зөрчилд 213 төлбөрийн акт тогтоож, 62.9 тэрбум төгрөгийн зөрчилд 412 шаардлага хүргүүлж, 3.4 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 26 албан шаардлага, 3.6 тэрбум төгрөгийн 4 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэж, 12.6 тэрбум төгрөгийн

алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 427 зөвлөмж өгсөн байна.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 228.8 тэрбум төгрөгийн 494 алдаа илэрснээс аудитын явцад 228.4 тэрбум төгрөгийн 456 алдааг залруулж, 0.3 тэрбум төгрөгийн алдааг залруулах 36 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийслэлийн асуудлаар 237.3 тэрбум төгрөгийн 368 зөрчил илэрснээс 3 шийтгэврийн зөрчил, 3 төлбөрийн акт тогтоож, 224.7 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 139 албан шаардлага, 0.6 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 2 албан шаардлага хүргүүлж, 12 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 224 зөвлөмж өглөө.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө нь 469.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий тайлан онд 172.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийн дүнтэй 106 төсөл, арга хэмжээ батлагдаж, гүйцэтгэснээс гүйцэтгэлээрээ 166.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ.

Гурав. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан 3 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, аудитын түүвэрт 2 байгууллага хамрууллаа.

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын сан санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлагдмал дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 250.4 тэрбум төгрөгийн 13 зөрчил илэрснээс 250.3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлж, 0.2 тэрбум төгрөгийн зөрчлийг

давтан гаргахгүй байх 7 зөвлөмж хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийслэлийн аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Дөрөв. Нийгмийн даатгалын сангийн 2023 онд санхүүгийн нэгтгэсэн тайланд 36 санхүүгийн тайлан нэгтгэснээс 32 байгууллагын санхүүгийн тайлан дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа.

Аудитаар Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 30 байгууллагын санхүүгийн тайланд өөрчилж буй 1 байгууллагын санхүүгийн тайлан хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар 125.6 тэрбум төгрөгийн 88 зөрчил илэрснээс 10.2 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 121.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 32 албан шаардлага хүргүүлж, 4.5 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 44 зөвлөмжийг өглөө.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 6.8 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 6.8 тэрбум төгрөгийн 32 алдааг залруулж, 18.1 сая төгрөгийн алдааг залруулах 5 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдсан нийслэлийн асуудлаар 2.9 тэрбум төгрөгийн 27 зөрчил илэрснээс 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож 1.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага хүргүүлж, 1.8 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 18 зөвлөмж хүргүүллээ.

Тус Байнгын хороонд аудитын дүгнэлтээс үндэслэн дараах асуудалд анхаарал хандуулахыг зөвлөж байна.

1.Төсвийн эрхлэн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулах.

2.Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгах.

3.Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулсан төсөвт ачаалал үүсгэж, тухайн хөрөнгө оруулалтын зардалтай холбоотой аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа тул төсвийн сахилга батыг сайжруулах.

Нийгмийн даатгалын сангийн Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 68.2 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах.

Чингис Хаан банк дахь харилцах дансанд байршиж байгаа 27.9 тэрбум төгрөгийн үлдэгдлийг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх талаар гарсан Шүүхийн шийдвэрийг хангуулах.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Нэгдсэн Үндэстний

Байгууллагын Хүн амын сангаас хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүүхдийн эрхийг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээнд олгосон гадаад эх үүсвэрийн санхүүжилтийн зарцуулалтад хүрсэн үр дүн, хэрэгжилтэд нь тавих хяналтыг сайжруулах.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон 6538 зээлдэгчийн 15.5 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг хангуулах арга хэмжээ авч сангийн эх үүсвэрийг бий болгох.

Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлтийг тоймлон танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Би өөрөө асуулт асуух гээд бүртгүүлсэн боловч орсонгүй. Миний нэрийг оруулаад. Дараа нь асуучхаж болох уу?

Ж.Баясгалан. Ж.Чинбүрэн гишүүнээр тасаллаа. Ж.Баярмаагийн нэр ороогүй байн. Орчихсон уу? М.Нарантуяа-Нара, Б.Бейсен, Ж.Баярмаа, Ж.Чинбүрэн гээд орж байна.

Ж.Баясгалан гишүүний микрофоныг нээнэ үү.

Ж.Баясгалан: Энэ өдрийн мэндийг хүргэе.

2023 оны гүйцэтгэлийн тайланг харж байхад Эрүүл мэндийн даатгалд хамрагсдын тоо 2023 онд 39 мянга 717 хүнээр, даатгалын орлого 364.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байгаа.

Ингээд хамрагсдын тоо Эрүүл мэндийн даатгалын орлого 16.6 тэрбум төгрөгөөр тасарсан дүн гарсан байна. Харин эсрэг талдаа.

Ингээд хүн нэмэгдээд, даатгуулагч нэмэгдээд, үйлчлүүлэгч нэмэгдээд, орлого нэмэгдсэн хэрнээсээ Эрүүл мэндийн даатгалын орлого нь 16.6 тэрбум төгрөгөөр тасарсан дүн гарсан байна.

Энэ орлого яагаад тасарсан юм бол оо? Энэ талаар хариулж өгөөч ээ.

Л.Энхнасан: Хариулт өгнө үү? Ажлын хэсгээс.

Т.Мөнхсайхан сайдын микрофоныг нээнэ үү. Нийгмийн даатгалын 7 дугаар микрофоныг нээнэ үү.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын хуульд заасны дагуу албан журмаар шимтгэл төлж ажиллаж байгаа даатгуулагч ажил олгогчоос цуглуулсан шимтгэлийн орлогыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт манайхаас, Нийгмийн даатгалын ерөнхий газраас төвлөрүүлж ажилладаг.

2023 онд бол 644.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэл 645.8 тэрбум буюу 97.3 хувийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж өгсөн.

Өнгөрсөн оны бодит гүйцэтгэлтэй харьцуулахад дунджаар 25 орчим хувь. Өөрөөр хэлбэл шимтгэлийн орлогын бодит цэвэр өсөлтийг 25 хувиар олж нэмэгдүүлэн олгосон гэж үзэж болно.

Тэгэхээр төлөвлөлт бол бас нэлээн өндөр байсан гэдгийг ташрамд нь хэлэх гэсэн юм. 97.3 хувийн биелэлттэй гарсан.

Эдийн засгийн бодит өсөлтийн гүйцэтгэл 25 байсан. Өнгөрсөн онд олсноосоо

Л.Энхнасан: М.Нарантуяа-Нара гишүүний микрофоныг нээнэ үү?

М.Нарантуяа-Нара: Сайн байцгаана уу?

Тэгэхээр 2023 оны төсөв дээр тодруулах хэд хэдэн зүйл байна.

Ер нь тодруулмаар их олон зүйл байгаа боловч анхаарал татаж байгаа зүйлүүдээсээ асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, 2023 оны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 96 тэрбум 307 сая байна уу, эсвэл 96 сая гэж байхгүй биз дээ. 96 тэрбум төгрөг төсөвлөсөн байна л даа.

Тэгээд энэ 92.9 хувьтай хэрэгжилттэй гэж үзсэн юм байна. Мөн үү? Энэ дээр би нэг асуулт асуумаар байна.

Энэ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн ямар ажилд зарцуулаад ингээд энэ үр дүнг хэмжсэн бэ? Яаж ямар одоо үнэлгээгээр энэ дүн үр дүнг хэмжсэн юм бэ?

Дээрээс нь яг энэ задаргааг нь хаанаас авах юм бэ? Энэ би төсвөөс хайгаад байхад яг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын энэ 96 тэрбум төгрөгийн задаргаа байхгүй байна. Энэ задаргааг үг танилцуулаач. Дээрээс нь үр дүнг нь яаж хэмжсэн юм бэ?

Хоёрдугаарт, Нийгмийн хамгааллын сайдын багцад эмэгтэйчүүдийн манлайллийг дэмжих төслийн тоног төхөөрөмж гээд Баянхонгор аймагт 403 тэрбум 700 сая төгрөг төсөвлөөд 100 хувьтай үнэлчихсэн байна.

Энэ яг ямар тоног төхөөрөмж Баянхонгор аймагт хэрэгжив ээ? Үүнийг асуух гэсэн юм.

Эрүүл мэндийн сайдын багцаас тодруулмаар байгаа зүйл байгаа.

“Эрүүл мэндийн сан” гэж байдаг. Тийм ээ. Эрүүл мэндийн сан дээр ийм задаргаа энд би олж харж чадсангүй.

Тэгэхээр эрүүл мэндийн сан дээр өнгөрөгч онд хэдэн төгрөг зарцуулагдсан бэ?

Дээрээс нь “Монголын эмэгтэйчүүдийн холбоо” гээд нэг байгууллага байдаг. Энэ байгууллага одоо төрийн бус байгууллага гэж хэлдэг. Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага гээд.

“Хавдаргүй монгол эмэгтэй” гэсэн ийм нийгмийн аян хэрэгжүүлсэн. Энэ дээр иргэдийн дунд Эрүүл мэндийн сангаас хэд хэдэн сая ч билээ, хэдэн зуун сая ч билээ авсан гээд яригдаад байдаг.

Энэ асуудлыг тодруулж өгөөч ээ.

Яг энэ “Хавдаргүй монгол эмэгтэй” нийгмийн аяны хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас хэдэн төгрөг зарцуулагдсан, төсөвлөгдсөн бэ? Тэрийг нь яаж хэмжиж байгаа вэ?

Гэтэл орон даяар нөгөө юу билээ? Урьдчилан сэргийлэх. Тийм ээ. Эрт

илрүүлэг гээд хөтөлбөр явагдаад байгаа шүү дээ. Иргэд хүссэнээрээ очоод заагдсан лабораториудад очоод. Үүнтэй чинь давхцал нэгдэхгүй юу, эсвэл өөр төрлийн үйлчилгээ байгаа юу?

Тэгээд дээрээс нь эрүүл мэндийн сангаас яг хүүхдэд зориулсан хэдэн төгрөгийн төсөв энд гарсан байна гэдгийг тодруулмаар байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Гишүүний асуултад хариулна уу. 7 дугаарын микрофоныг нээнэ үү. 3 дугаар микрофон байна шүү. 3 дугаар микрофоныг нээнэ үү.

Д.Очирбат: Эрхэм гишүүний асуултад хариулъя.

“Эрүүл мэндийг дэмжих сан” гэж Эрүүл мэндийн яаман дээр байдаг. Энэ бол сайдын багцад дэмжих сангийн хүрээнд өнгөрсөн жил, түрүү түрүүчийн жилдээ 2 тэрбум төгрөг тавьж төсөл хөтөлбөр, эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, хамгаалах сургалтад зориулсан дэмжлэг үзүүлдэг ийм сан байдаг.

Таны асуусан Монголын эмэгтэйчүүдийн холбоонд “Хавдаргүй монгол эмэгтэй” гэдэг дээр санхүүжилт энэ сангаас гараагүй.

Мөн түрүүний адил “Хүүхэд хамгааллын сан” ч гэсэн бас энэ сангаас мөнгө гараагүй ээ гэдгийг.

Л.Энхнасан: 7 номерын микрофоныг нээе. Асуултад хариулъя.

Л.Мөнхзул: Баянхонгор аймгийн эрх шилжүүлж хэрэгжүүлсэн төсөл.

“Эмэгтэйчүүдийн манлайлалыг дэмжих” төслийн тоног төхөөрөмж гээд 400.3 сая төгрөг 2022 оны төсөв дээр

тусгагдаад, 2023 онд санхүүжсэн дүн үлдэгдэл санхүүжилт 53.7 сая төгрөг санхүүжигдсэн байна.

Энэ нь задгайгаараа явж байгаа юм байна. Тэрбумаар биш. Энэ дээр 53.7 сая төгрөг л 2023 онд гүйцэтгэлээр зарцуулагдсан. Энэ нь Баянхонгор аймагт эрх шилжиж, Баянхонгор аймгийн засаг захиргааны нэгжээс зарцуулсан хөрөнгийн дүн байна.

Л.Энхнасан: Тодруулга. М.Нарантуяа-Нара гишүүний микрофоныг нээнэ үү.

М.Нарантуяа-Нара: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 96.0 тэрбум уу? Тийм ээ. Эсвэл 96.0 сая гэж байхгүй байх гэж бодож байна.

Саяын энэ юун дээр. Одоо жишээлбэл Баянхонгор аймагт 403 сая төсөвлөсний 53 сая 700 нь өгөгдөөд, үлдэгдэл нь энэ онд шилжиж ирнэ гэсэн үг үү? Тийм ээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргаас үүнийг дахиад тодруулъя.

Хоёрдугаарт, нөгөө Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт төсөвлөгдсөн хэрэгжилт нь энэ үлдэгдэл 1 тэрбум 600 хэдэн сая нь энэ жил өгөгдөх юм байх даа. Энэ 96 тэрбумын задаргааг ярьсан юм шүү дээ.

Тэгээд дээрээс нь үүний үр дүнг нь яаж хэмжээд 92.9 хувьтай гээд хэмжчихсэн байна гэдгийг нь асуусан байгаа.

Хоёрдугаарт, “Эрүүл мэндийг дэмжих сан” руу оруулж байх шиг байна. Ямар ч л байсан “Эрүүл мэндийн сан” гэж байдаг биз дээ. Дэмжих сан гэж байгаа юу. Тийм ээ. Ойлголоо.

Тэгвэл ямар ч байсан Монголын Эмэгтэйчүүдийн холбоо.../минут дуусав/

Л.Энхнасан: Хариулт өгнө үү? 3 дугаар микрофон.

Д.Очирбат: Түрүүн хэлсэн. “Эрүүл мэндийг дэмжих сан”-гаас “Монголын эмэгтэйчүүдийн холбоо”-нд санхүүжилт гараагүй.

Л.Энхнасан: Нэмэлт хариултыг 7 дугаар микрофоноос хариулна уу. Гишүүний асуултад.

Л.Мөнхзул: М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Л.Мөнхзул.

Нэгдүгээрт, эмэгтэйчүүдийн манлайлал төслийн хүрээнд олгосон санхүүжилтийн дүн 2022 оноос эхлээд 2023 онд гүйцэтгэл 53 саяыг олгосон гэсэн үг.

Ингээд гүйцэтгэл нь дууссан. Арга хэмжээ.

Эхэлж байгаа нь 2022 он. Дуусаж байгаа нь 2023 оны гүйцэтгэлээр олгосон.

Хоёр дахь асуудал. Тэр 91 тэрбум гэдгийг бас хаанаас гаргаж ирснийг нь бид хэд бас нягталъя.

Гэр бүл, хүүхэд залуучуудын салбарын 2023 оны төсвийн нийт батлагдсан төсөвт зарцуулсан зардал маань 34.3 тэрбум төгрөг. Энэ дотор юу ордог вэ гэхээр 7.9 тэрбум төгрөгөөр “Хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөр”.

Энэ дотроо хүүхдийг “урьдчилан сэргийлэх”, “нөхөн сэргээх тусламж”.

үйлчилгээ”. Мөн “хамгаалах үйлчилгээ” гэсэн 3 багц үйлчилгээний хүрээнд явдаг.

Ер нь төсвийн тухай хуулийн хавсралт 1-ээр тухайн төсвийг зарцуулснаар тухайн жилийн хүрээнд ямар үр дүнд хүрэх вэ гэдэг шалгуур үзүүлэлтүүдийг Улсын Их Хурлаас хуулиар баталж өгдөг.

Энэ хуулийн хүрээнд хэрэгжилтийг Аудитын газраас үнэлж үнэлгээг нь 92 уу, хэдэн хувь вэ гэдгийг нь тавьдаг.

Тэгэхээр энэ бол төсвийн гүйцэтгэлийн шууд уялдаатай гэхээсээ илүү тухайн жилд дэвшүүлсэн, тухайлбал нийгмийн даатгалын үйлчилгээний чанарыг хэрхэн хэрэгжүүлэв, нийгмийн хөгжил хамгааллын үйлчилгээнд хамрагдах ёстой хүүхдийн оролцооны түвшин хэд байв гэсэн чанарын үзүүлэлт дээр уялдаж дүгнэгддэг үзүүлэлтүүд гаргасан байх гэж үзэж байна. Тийм.

Гэр бүлийн хөгжил, хамгааллаар улсын хэмжээнд 2023 онд зарцуулсан зардал 570 сая төгрөг л байгаа.

Л.Энхнасан: Тодруулгын минут дууссан. Б.Бейсен гишүүний микрофоныг нээнэ үү.

Б.Бейсен: Эрүүл мэндийн яамнаас асууя.

Гадаадад эмчлүүлэгчдийн зардал гээд бид 10 тэрбум төгрөг хуваарилсан. Энэ тайлан дээр тусгагдаагүй тэрний хэчнээн төгрөгийг нь зарцуулсан юм, хэчнээн өвчтөн гадаад явсан юм, хэчнээн өвчтөн дээр дэмжлэг үзүүлсэн бэ гээд асууя.

Хоёрдугаарт, энэ “13-ын А, Б” маягт гээд хүчингүй болгосон. Гэтэл энэ

халамж, үйлчилгээний газар, нийгмийн даатгалын чиглэлээр Улаанбаатар хотод эмчлүүлж байгаа, заавал эмнэлгийн шийдвэрээр хот явж байгаа өндөр настнуудад нэг талын зардал олгох ёстой. Үүнийг төсөв дээр тавьсан бид нар.

Гэтэл энэ асуудал дээр ард иргэд олноор чирэгдэж байгаа. Энэ төсөвлөгдсөн зардлаас чинь хэчнээнийг зарцуулсан юм.

Сая сайдын “13 А, Б” маягт нөгөө талаар хуулийн бичиг баримт. Яах аргагүй чухал баримтыг урд сайд ингээд шаардлагагүй гээд яачихсан.

Тэгэхээр хүн болгон хот руу яваад. Зардал нь их аюул бий. Энд.

Тэгэхээр заавал хот явах шийдвэр гарсан тохиолдолд зардлаа авах нөхцөл бүрдэх ёстой л доо. Энэ тал дээр сайд цаашдаа тэр халамж, үйлчилгээнийх нь төсвийн зарцуулалтыг асууя.

Дараа энэ дуусдаггүй нэг хэдэн барилга бий. Хотгорын эмнэлэг. 7 дугаар баг гээд явдаг. Хотгорын уурхай өдөрт 100-аас 150 машин очдог. Тэнд сургууль, эмнэлэг, цэцэрлэг байсан.

2018 оны сүүл, 2019 онд батлагдсан юу чинь одоо хүртэл тэгээд л баригдахгүй бүр орыг нь цомхотгоод. Тэнд чинь аваар осол гардаг. Аймгаас алслагдсан. Жирэмсэн эхчүүд байдаг.

Энэ төсвийг нь авчхаад сая би очоод үзсэн. Дахиад бариагүй. Энэ дээр Эрүүл мэндийн яам, аудитын газрынхан хяналт хийж үзсэн үү? Ингээд улсын төсөв үрэн таран хийж байх уу?

Мөн Буянт сумын сургуулийн барилга байна. Мөн 2019 онд эхэлсэн. Одоог хүртэл тэгээд 5 тэрбум хэдэн зуун

сая төгрөгийн юм авчхаад одоог хүртэл барилгыг нь дуусгадаггүй. Ийм юман дээр хяналт хийхгүй бол энэ дээр төсөв харж байсан чинь бүгдийг нь олгочихсон байх юм.

Энэ дээр ямар байр суурьтай байна. Ер нь шалгаж яасан уу? Энэ төсөв одоо ингээд үрэн таран хийж байх уу?

Мөн Улаанчулуу баг, Ховд багийн эмнэлгийн асуудал байж байна. Үүнийг бас төсвийг нь тавьсан уу? Эмнэлэг нь баригдчихсан байгаа.

Би 1 минут.

Л.Мөнхнасан: Т.Мөнхсайхан сайдын микрофоныг өгнө үү.

Т.Мөнхсайхан: Гишүүний асуултад хариулъя.

Эрүүл мэндийн дэмжих сан дээр тавигдсан мөнгө Та ярьж байх шиг байна. Тийм ээ.

Монголд эмчлэгдэх боломжгүй өвчнийг гадаадад эмчлүүлсэн тохиолдолд насанд хүрсэн хүнд зардлын 20 хувь хүртэл олгох, хүүхдийн 50 хүртэл хувийг.

Тэр чинь энэ оны төсөв дээр шүү дээ. Одоо хэдүүлээ өнгөрсөн жилийн юу ярьж байгаа гэж бодож байна.

Тэгээд энэ “Эрүүл мэндийн дэмжих сан” дээр тавигдсан 9.6 тэрбум төгрөг нь өөрөө эргүүлээд бас энэ нийгмийн эрүүл мэнд рүү чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулагдах, дээрээс нь Монгол Улсад эмчлэгдэхгүй байгаа өвчнийг эмчилдэг болгоход зарцуулах ёстой учраас гадаадад Монгол Улсад эмчлэгдэхгүй байгаа өвчтнийг эмчлэх чиглэлээр явж

байгаа боловсон хүчнүүдийн сургалтад зарцуулалт нь хийгдэж байна.

Нөгөө талдаа энэ сургалтад яваад ирсэн улсууд эргээд шинэ тоног төхөөрөмжийн шаардлага болдог учраас түүнд зарцуулагдахаар бас ингээд төлөвлөгдөөд, төсөвлөгдөөд явж байна.

Тэр “13-ын А, Б” маягт яалт ч үгүй аль ч улс оронд байдаг. Анхан шатаас дараагийн шат руу эмнэлэгт очихын тулд зайлшгүй анхан шатаасаа шилжих бичгийг авч очиж байж энэ эмнэлгийн ачаалал тэгш тэнцвэртэй байдаг.

Энэ “13-ын А” маягт байхгүй болсноос хойш ачаалалтай байдаг 1, 2, 3 дугаар эмнэлэг, хавдрын гээд лавлагаа шатлалын төв эмнэлгүүд гээд байгаагийн чинь ачаалал нь бас 20 орчим хувиар дээшээ нэмэгдчихсэн.

Тэгэхээр бид цаашдаа үүнийг ер нь зохицуулалтыг зөв хийж анхан шат болон аймаг, дүүргийн эмнэлэг дээр тодорхой тусламж, үйлчилгээг нь үзүүлдэг болох нь зөв өө. Тэндээсээ дараагийн шатлал руу харин хэрхэн яаж шилжүүлэх вэ? Заавал цаасаар нэг маягт бариад яваад байх биш, өрх, сум, дүүргийнхээ эмнэлгээс үзүүлсэн хүмүүсээ дараагийн шатлалын эмнэлгийнх нь цагийг цахим хэлбэрээр авчихдаг энэ бодлого руу ер нь шилжиж орохоор төлөвлөөд ажлууд нь эхнээсээ хийгдээд явж байгаа гэж ойлгож болно.

Тэгээд хөдөө орон нутгаас ирж байгаа улсуудын тэр замын зардал, нийгмийн асуудлыг Эрүүл мэндийн даатгалын сан хариуцахгүй.

Эрүүл мэндийн даатгалын сан зөвхөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнийхээ чиглэлийн санхүүжилтийг олгоно.

Тэр бол халамж талдаа, нийгмийн даатгал талдаа хариуцах асуудал болов уу гэж бодож байна.

Ер нь дуусаагүй баригдаад эхэлчихсэн барилгуудыг зөвхөн дуусгах төсвүүд бас дараа дараагийн онуудад тавигдана гэж ер нь ингэж тооцоолж байгаа. Шинээр ямар нэгэн байдлаар нь тийм эмнэлэг, сургуулийн барилгуудыг энэ удаагийн төсөвт тусгахгүйгээр явж байгаа.

Манай Эрүүл мэндийн яамны зүгээс шаардлагатай бүхий л санал, хүсэлтээ өгөх.../минут дуусав/

Л.Энхнасан: Ажлын хэсгээс гишүүний асуултад хариулна уу. 3 дугаар микрофон өгнө үү.

Д.Очирбат: Эрхэм гишүүний асуултад хариулъя.

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат байна.

Түрүүн Эрүүл мэндийн сайд хэлсэн. 2024 оны Эрүүл мэндийн даатгалын санд нэмэлт, өөрчлөлт ороод олон асуудлуудыг шийдэж өгсөн. Хувь хэмжээнүүдийг нэмж өгсөн.

2024 оны гүйцэтгэлээр 735 сая төгрөгийг гадаад эмчилгээнд одоогийн байдлаар олгосон байна.

Тэр Хотгорын эмнэлэг 2018 оноос хойш, 2019 онд 250 сая төгрөг тавиулж энэ эмнэлгийн ажлыг эхэлсэн. Үүнийг шууд орон нутагт нь эрхийг нь шилжүүлээд баригдах эрхийг нь шилжүүлсэн. Тендер зарлах эрхийг нь шилжүүлсэн.

Өнөөдрийн байдлаар энэ “Үлийдалай” гэдэг компани тухайн үед нь бас зөрчилтэй асуудлууд явагдаж байгаад, зураг төсөл баригдаагүй, хийгдээгүй тийм асуудлууд явсаар байгаад 2023 онд 1 тэрбум 3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг тавьж өгсөн. Одоо энэ асуудлууд шийдэгдээд явж байгаа.

“Улаан хад” эмнэлэг. 2025 оны төсөв дээр бид Сангийн яаманд төсвийн төсөл дээрээ бас санхүүжүүлдэг сангийн төсвийг нь тавьж өгсөн. Тэгээд 2025 оны төсвийн төсөл дээр хэлэлцэгдэнэ.

Л.Энхнасан: Б.Бейсен гишүүний тодруулгын хугацааг нэмнэ үү.

Б.Бейсен: Тэгэхээр тэр Улаанчулуу, Ховд баг дээр чинь сургууль, цэцэрлэг байгаа. Нэлээн олон хүүхэд сурч байгаа.

Эмнэлэг нь баригдчихсан. Одоо ядахдаа тэнд нэг эмч, сувилагч нь суугаад тариа хийдэг, үздэг байхгүй бол тэнд чинь ганцхан багийн бага эмч гээд нэг юм явдаг. Тэгээд орон тоо, энэ тэрийг нь баталж өгөхгүй бол тэнд чинь бараг сумын дайтай багууд шүү дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ дуусаагүй барилгууд дээр хяналт хийхгүй бол наад Хотгорын энэ чинь том уурхайтай газар аваар осол гардаг. Тэндхийн ажилчдын тэр жирэмсэн эхчүүд байж байна, хүүхдүүд байж байна.

Жилийн жилд төсөв нэмүүлээд сурчихсан. Нөгөө аймгийн төлөөлөгчдийг шагналын журмын тендер авсан улсууд байхгүй юу.

Энэ дээр энэ аудитын газрууд чинь ерөөсөө хяналт хийхгүй бол ер нь нэлээн ноцтой асуудлууд байж байгаа.

Л.Энхнасан: Асуулт биш. Илүү үг хэллээ гэж ойлголоо.

Ж.Баярмаа гишүүний микрофоныг өгнө үү.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Хоёр, гурван асуулт байна. Энэ аудитын тайлангаас харж байхад.

Энэ бараа, материал, авлага, өглөг гээд. Тийм ээ. Зөндөө л ангиллууд байна л даа.

Зүгээр бараа, материалаас харж байхад илүү хэрэггүй бараа, материал, эсвэл ашиглалтгүй бараа, материал гээд маш өндөр дүнгүүд байна л даа.

Тэгээд энэ Байнгын хороотой холбоотой асуудлаар сайдуудтай холбоотой асуудлаар гэж асуухад жишээлбэл Эрүүл мэндийн сайдын хүрээний асуудал гэх юм бол 1.3 тэрбум төгрөгийн бараа илүүдэлтэй байна гэж гарсан байна. Энэ ямар бараа байдаг юм бол оо? Яагаад ийм олон тэрбум, одоо их хэмжээтэй мөнгөтэй бараа илүүдчихсэн байдаг юм бэ гээд.

Авлага гэдэг дээр бас нөхцөлгүй их авлагатай юм байна. Манай салбарууд.

Одоо найдваргүй болчихсон, олон жилийн насжилттай ийм авлага гэхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад 37 тэрбум төгрөг ногдож байна.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” гэх юм бол 20.8 тэрбум төгрөгийн авлага байна.

Барагдуулах арга хэмжээ огт аваагүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий луу шилжүүлээгүй гээд дахиад 23 тэрбум төгрөгийн авлага Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад байна.

Тэгэхээр энэ их авлагуудыг авах ажиллагаанууд хэр явагддаг юм бэ? Юунд, ямар учраас ийм их олон тэрбум төгрөгийн авлагатай болчихсон байдаг юм бэ?

Энд аудитын тайлан байна л даа. Нийт 487 тэрбум төгрөгийн зөрчил гээд. Энэ чинь одоо бараг хагас их наяд төгрөгийн зөрчил байна.

Тэгээд зөрчил гаргасан 97 албан тушаалтныг бас хариуцлага тооцуулахаар холбогдох байгууллагуудад шилжүүлсэн гэж байна.

Тэгэхээр энэ мөнгөн дүн, энэ хариуцлага тооцуулах албан тушаалтнуудын хэдэн хувь нь эрүүл мэндийн салбар бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын энэ салбарт харьяалагдаж байгаа вэ?

Тэгээд энэ хариуцлага тооцох механизм ер нь яаж явагддаг юм бэ? Хариуцлага тооцож байгаа болов уу гэсэн ийм хэдэн асуулт байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Т.Мөнхсайхан сайдын микрофоныг нээнэ үү. Хоёр сайдаас хоёулангаас нь асууж байна гэж ойлголоо.

Т.Мөнхсайхан: Одоо тэр илүүдэл үүсгээд байгаа нь, би бодохдоо 2022 онд нөгөө КОВИД-ын үед бэлэн байдал хангаж авсан бараа, бүтээгдэхүүний асуудлыг илүүдэл гэж тооцсон болов уу.

Тэр илүүдэл биш. Дараа дараагийнхаа жилүүдэд ер нь хэрэглэгдээд явах байх.

Тэр авлагын асуудал нийгмийн даатгалын авлагын асуудлыг ярьж байгаа байх. Энэ нөгөө банкнудтай холбоотой асуудал дээр нийгмийн даатгалынхан илүү их хариулт өгөх болов уу?

Энэ дээр зүгээр тодруулаад хэлэхэд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар хоёр чинь цуг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхаа харьяанд байсан юм.

Тэгээд 2016 онд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар ер нь биеэ дааж эрүүл мэндийнхээ салбар луу шилжиж ирсэн.

Хоёр банктай холбоотой авлагын асуудал 2012 оноос 2016 оны хооронд үүссэн асуудал учраас энэ дээр Нийгмийн даатгалын ерөнхий газрынхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан илүү тодорхой хариулт өгөх байх гэж бодож байна.

Л.Энхнасан: Л.Мөнхзул Төрийн нарийн бичгийн даргын микрофоныг нээнэ үү. 7 дугаар.

Л.Мөнхзул: Найдваргүй авлага 34 тэрбум байгаа.

Үүнтэй холбогдолтой хоёр асуудал байгаа. Үүнийг манай “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” яг харьяанд нь байдаг. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд тайлбар өгч болох уу?

Л.Энхнасан: 5 номерын микрофон дээр суугаад хариулна уу. 5

номерын микрофоныг өгнө үү. 7 дугаар микрофоныг өгнө үү.

З.Энхболд: Гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд.

Ер нь хугацаа хэтэрсэнтэй холбоотой хэд хэдэн авлагын асуудал байдаг.

Энэ дээр нэгдүгээрт Оёдлын нэгдсэн холбоотой 13 тэрбум төгрөгийн авлага байдаг. 2013 онд Засгийн газрын 253 дугаар тогтоол гараад тухайн үеийн Хөдөлмөрийн сайдад эрх олгоод, Хөдөлмөрийн сайд Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд хооронд эрх шилжүүлсэн шийдвэрийн дагуу энэхүү мөнгийг Хөдөө аж ахуйн яаманд шилжүүлээд. Үүнийхээ үндсэн дээр тухайн үед сурагчдын дүрэмт хувцсыг оёулахаар Оёдлын нэгдсэн холбоонд шилжүүлээд олгочихсон юм билээ.

Тэгээд үүнтэй холбогдуулаад авлага барагдуулах ажил удааширсан. Одоо 11 жилийн хугацаанд энэ авлагыг барагдуулах процесс явж байгаа.

Хоёрт нь, энэ Капитал банктай холбоотой. Капитал банкан дээр 3.8 тэрбум төгрөгийн авлага байдаг. Үүнтэй холбогдуулаад бид өнгөрсөн жил Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд танилцуулаад зарим үл хөдлөх хөрөнгүүдийг улсын орлого, авлагадаа хүлээж авахаар санал болгосон. Тухайн үед дэмжигдээгүй.

Дээрээс нь бид нэг тээврийн хэрэгслийг бас энэ өртөгтөө хүлээж авсан.

Одоогоор бас нэг объект хүлээж авахаар бид ирүүлсэн саналын дагуу

бүрэн эрхт төлөөлөгчийнх нь санал болгосон саналын дагуу хүлээж авах ажил явж байна.

Гуравт нь, Анод банкттай холбоотой авлагын асуудал байдаг. Анод банкны авлагыг нийтдээ 800 сая төгрөг байгаа.

800 сая төгрөгийн хувьд одоогоор шүүхийн шийдвэр нь гарсан боловч үүнийг шийдвэр гүйцэтгэл хийх боломжгүй буюу хариуцагч нь байхгүй болсон. 2020 оноос хойш энэ бүрэн эрх төлөөлөгчийнх нь бүрэн эрхийн хугацаа дууссантай холбоотой энэ асуудал ингээд бүрэн зогсчихсон ийм байдалтай байж байгаа.

Л.Энхнасан: Нэмэлт хугацаа өгье. 7 дугаар микрофон.

3.Энхболд: Жижиг зээлүүдтэй холбоотой асуудал байдаг.

Энэ дээр санхүүгийн дэмжлэг болон жижиг зээлийн дэмжлэгийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаас олгодог.

Үүнтэй холбогдуулаад иргэдийн санхүүгийн дэмжлэгээр олгосон үйлчилгээ нь барьцаагүй явдагтай холбогдуулаад эргэн төлөлт удааширсан ийм зүйл байгаа.

Үүнийг 2024 оны 5 сарын 15-ны өдрийн Засгийн газрын тогтоол гарч Засгийн газрын 2023 оны 340 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулаад Монголбанкны мэдээллийн санд нийлүүлэлт хийдэг болсонтой холбогдуулаад энэ зөрчлийг арилгах арга хэмжээ үргэлжлээд явж байгаа.

Л.Энхнасан: Ж.Баярмаа гишүүний микрофоныг өгье. Нэмэлт тодруулга.

Ж.Баярмаа: Тэгэхээр энэ дээр банкнуудтай холбоотой асуудал байна л даа. Асар олон жил дамнаад явчихсан.

Гэхдээ 23 тэрбум төгрөг гэхэд барагдуулах арга хэмжээ аваагүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт шилжүүлээгүй гэсэн маш тодорхой ийм дүгнэлт байгаа шүү. Энэ бол бага мөнгө биш шүү.

Яагаад энэ мөнгөнийхөө араас явдаггүй юм бэ? Үүний чинь цаана нөгөө авлига, албан тушаалын хэрэг нуугдаж байдаг юм биш биз дээ.

Янз бүрийн арга замаар баахан зээл өг гэдэг юм уу, эсвэл ямар юм болдог юм. Бүү мэд. Тэгээд эргэж үүнийгээ татан төвлөрүүлэх арга хэмжээ огт авдаггүй.

Ингээд авлага нэртэйгээр насжилт удаантай авлагын ангилалд ороод мартагдаж байна шүү. Энэ дээр ерөөсөө шинэ сайдууд маш дорвитой арга хэмжээ авахгүй бол үүний цаана чинь нөгөө хулгай явж байгаа шүү.

Хоёрдугаарт, Т.Мөнхсайхан сайд сая хэллээ л дээ. Энэ бараа, материалын илүүдэл гээд. Бүхэл бүтэн энэ чинь аягүй олон тэрбум байгаа байхгүй юу. 4.4 тэрбум төгрөг.

Тэгэхээр энэ бол маш тодорхой бичсэн байна. Хугацаа хэтэрсэн, хадгалалтын. Ашиглалтгүй, эргэлт нь удааширсан. Ер нь энэ бол ямар ч нэмэргүй хэрэггүй ингээд бараг хог болоод байж байгаа ийм бараа, материал шүү гэж тодорхойлсон байна. Аудитын дүгнэлтээр.

Дээр үед Эрдэнэтэд бас хэдэн тэрбум төгрөгийн, их муухайгаар хэлбэл бараг юу билээ, нэг бэлгэвч авчихсан байсан гэдэг нэг домог шиг яриа явдаг шүү дээ.

Түүн шиг шахам юмнууд ингээд энэ бараа, материалын илүүдэл дотор чинь явж байдаг юм биш биз дээ.

Тэгэхээр хойшид нэг иймэрхүү маягийн татвар төлөгчдийн мөнгөөр ерөөсөө жаалж байна шүү дээ. Тэгж л харагдаж байна. Энэ аудитын дүгнэлтийг харахаар.

Тэрбум төгрөг гэдэг чинь ерөөсөө зүгээр жирийн иргэдийн нэг хэдэн зуун төгрөгтэй агаар нэг болчихсон юм биш үү л гэж санагдаж байна.

Тэгээд одоо энэ зөрчлийн талаар бас хэлээд өгөөрэй. 487 тэрбум гэдэг чинь одоо хагас их наяд шахам төгрөгийн зөрчил гарчихсан явж байна шүү дээ. Тэгээд энэ дээр ямар арга хэмжээ авч байгаа юм бол оо?

Л.Энхнасан: Т.Мөнхсайхан сайдын микрофоныг өгнө үү.

Т.Мөнхсайхан: Ж.Баярмаа гишүүний хэлж байгаа бол үнэн. Тэрбум гаруй төгрөгөөр эрүүл мэндийн маш олон тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бараа материал, хэрэгсэл авчих ийм боломжтой. Энэ бол их хэмжээний мөнгө.

Тэгэхээр КОВИД-ын үед бэлтгэл ажил хангахдаа ямар нэгэн тооцоололгүйгээр илүүдэлтэй материалууд авсан ийм тохиолдлууд гарсан гэж ойлгож байгаа.

Энэ дээр яг ямар бараа, материалууд, ямар ямар зүйлүүд илүү гарсныг Д.Очирбат Төрийн нарийн тодорхой энэ дээр нь мэдээлэл өгөх хэрэгтэй.

Эрүүл мэндийн даатгалын сангийн хувьд тэр Нийгмийн даатгалын ерөнхий газраас түрүүний ярьсан тэр банкуудын өр ирэхдээ Эрүүл мэндийн даатгалд бас тал хувь нь шилжиж ирсэн. Энэ дагуу өмнө нь сайд хийж байх хугацаандаа ч тэр, арга хэмжээнүүдийг аваад шүүхэд нь өгөөд, шүүхийн шийдвэрүүдийг нь гаргаад үүнийг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өгөөд тодорхой хэмжээний өр төлбөрүүдийг бас барагдуулаад авчихсан байж байгаа.

Гэхдээ одоо аваагүй, авах ёстой 106 орчим тэрбум төгрөгийн ийм авлага байж байгаа.

Тэгэхээр энэ нь эргээд манай Эрүүл мэндийн даатгалын санд байгаа мэт бодогдоод тооцоолоод яваад байдаг. Энэ нь манай Эрүүл мэндийн даатгалын санд их хүндрэл учруулж байгаа юм.

Тэгэхээр үүнийг цаашид нь ер нь барагдуулах тал дээр шүүхийн шийдвэр, хууль хяналтынхан сайн дорвитой арга хэмжээ авч өгөөсэй л гэж хүсэж байгаа.

Одоогоор дахиж Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгийг ямар нэгэн хувийн арилжааны банканд хадгалах боломжгүй болсон шүү дээ.

2020 онд хуулийн өөрчлөлтийг хийгээд. Өмнөх би сайд хийж байх хугацаанд хуульд нь өөрчлөлт оруулаад, зөвхөн Төрийн санд байрлах боломжтой ийм хуулийн зохицуулалт хийчихсэн.

Тэгэхээр дахиж ийм хулгай гарах боломжгүй.

Одоо харин өнгөрсөн хугацаанд гарсан энэ хулгайг л барагдуулах тал дээр тал талаасаа анхаарах хэрэгтэй байна л гэж бодож байна.

Л.Энхнасан: Д.Очирбат дарга нэмж асуултад хариулна уу. 3 дугаар микрофон.

Д.Очирбат: Гишүүний асуултад хариулъя.

Ер нь КОВИД цар тахлын үед Эрүүл мэндийн яам Монгол Улсынхаа бүх иргэдийг 87.5 хувийн 3 тунгийн вакцинд хамруулсан.

Вакцинд хамруулах, урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг дэлхийн хэмжээнд шилдэг тэргүүнд тооцогдохоор Монгол Улсын Засгийн газар хамруулсан гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас үнэлж дүгнэдэг.

КОВИД-ын дараагаар маш олон хувилбарууд дэгдэж гарсан. Жишээлбэл, “альфа” хувилбар, “омикрон” хувилбар гээд.

Энэ хувилбаруудад бас Монгол Улсын Засгийн газраас вакциныг татан авалтуудыг хийж, нөөцүүдийг бэлтгэж ажилладаг. Энэ хүрээнд бид таталдан авалтынхаа 10-аас 15 хувийн нөөцтэйгөөр нөөц байдлаар таталдан авалтуудыг хийдэг.

Монгол Улс 1.5 жилийн өмнө КОВИД цар тахлыг ялан дийлж, хорио цээрээ цуцалж, ялан дийлсэн гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллага зарласан.

Үүнтэйгээ холбогдоод тодорхой хэмжээний тэр 10 хувийн үлдэгдэл, тодорхой хэмжээний илүү нөөцийн

үлдэгдлээс энэ вакцины үлдэгдлүүд байсан гэдгийг бас хэлмээр байна.

Л.Энхнасан: 4 дүгээр микрофоныг өгнө үү?

Л.Лувсан: Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан.

Авлагатай холбоотой хоёр тайлбар өгье.

Эрүүл мэндийн сайдын багцын нэгтгэсэн тайлангаар 182.8 тэрбум төгрөгийн авлагатай гарсан байгаа. Үүний 171 тэрбум төгрөг нь эрүүл мэндийн байгууллагууд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага байгаа.

Тэгээд цаана нь 11 тэрбум төгрөг бол бусад авлага байгаа.

Тэр бараа материал, нөөцийн барааны үлдэгдэл 280.7 тэрбум төгрөгийн бараа материалын авлагатай. Сайдын багцын нэгдсэн тайлан 450 байгууллагын тайлан нэгтгэж байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: Яг гишүүний асуусан асуулт дээр хариулсангүй. Тэнд ажлын хэсгээс хэн хариулах вэ? Хариуцлага тооцох асуудал дээр. Түүнд хэн хариулах вэ? 6 дугаар микрофон.

Я.Самбууням: Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням байна. Ж.Баярмаа гишүүний асуултад хариулъя.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бид аудит хийсэн байгаа. Аудитаар өмнөх аудитаар өгсөн Анод банк болон Капитал банкнаас авах авлагыг, мөн Оёдлын нэгдсэн холбооноос авах авлагуудын асуудлыг шийдвэрлээгүй.

Тэгээд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрээс олгосон 2014-2022 онд олгосон санхүүжилтийг авлагыг авах талаар арга хэмжээ авч ажиллаагүй холбогдох албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т зааснаар хариуцлага тооцох саналыг төсвийн ерөнхийлөн захирагчид нь хүргүүлсэн байгаа.

Бидэнд одоогоор энэ албан шаардлагын хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сард ирүүлэх ёстой байгаа. Одоогоор хариуг ирүүлээгүй байна. Баярлалаа.

С.Эхнасан: Ж.Чинбүрэн гишүүний микрофоныг нээнэ үү.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Би үг хэлнэ. Тэгээд миний хугацааг 1 минутаар нэмчхээрэй.

Тэгэхээр нэгд аудитын дүгнэлтэд 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд маш чухал зүйлийг хөндсөн байгаа. Энэ бол ерөөсөө л Эрүүл мэндийн даатгалын сангийн өрийн асуудал байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, аргачлалыг бодитой тодорхойлоогүйгээс сангийн эх үүсвэр хүрэлцэхгүй 218.3 тэрбум төгрөгийн өртэй байна гэж.

Үүнтэй холбоотой би бас нэлээн хэдэн зүйлийг хэлье гэж бодож байна.

2020 онд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн даатгалын санд өөрчлөлт оруулах хуулийн төслүүд, эрүүл мэндийн хуульд оруулах өөрчлөлтүүд, тэр ажлыг бас ахалж

ажилласан хүний хувьд бид нэг үндсэн том зарчимд тохирсон.

Энэ бол эмнэлгийн тусламж шаардлагатай иргэн бүрт тусламж, үйлчилгээг хувь болон улсын эмнэлгийн өмчлөлөөс үл хамааран хүргэснийх нь төлөө санхүүжилтийг жигд хүртээмжтэй хүргэнэ.

Хоёрт, тааз байхгүй. Хуучин 2020 оноос өмнө бол та жилд 2 сая төгрөгөөс илүү өвдөж болохгүй гэдэг байсан бол бид 2020 оны парламентын анхны ээлжит бус чуулганаар энэ хуулийг батлахдаа өвчин тусаад эмчилгээнийхээ төлбөрийг ямар нэг хязгаарлалтгүйгээр эмчлүүлснийхээ төлөө авах боломжтой болгосон.

Нөгөө талаасаа эмнэлгийн байгууллагууд нь эмчилгээ, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө өрөнд ордог байх тогтолцоог бид батлаагүй шүү.

Тийм учраас энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоо өөрөө Монголын эрүүл мэндийн салбарыг зөв голдиролд нь оруулсан. Тэр ч утгаараа одоо гүйцэтгэлийн санхүүжилтийн энэ үүсээд байгаа олон олон төвөгтэй асуудлууд, энэ өр ширийн асуудлууд, үүнийг Засгийн газар зайлшгүй шийдвэрлэх ёстой.

Тийм учраас яагаад тэгсэн юм, тэр юунаас болсон юм гэж яримааргүй байгаа юм.

Би Байнгын хороон даргадаа бүр зориуд ажлын санал гаргамаар байна. Бид ажлын хэсэг байгуулъя. Байнгын хорооноосоо Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлтэй холбоотой гүйцэтгэлийн санхүүжилт нь болохгүй байгаа, болж байгаа эерэг, сөрөг талуудыг судлах ажлын хэсэг гаргая.

Энэ ажлын хэсгээрээ дамжуулаад гүйцэтгэлийн санхүүжилт ер нь ямар байгааг асуухгүй бол 2024 оны тайланд дахиад энэ орж ирэх байхгүй юу. Дахиад л бид нэг ийм юмтай тулаад л сууна.

Хоёрт, би эмийн сонголт хийсэн. Эмийн талаар хийсэн хаврын сонголоос 11 сард холбогдох байгууллагууд тайлангаа тавина. Үүгээр нэлээн олон зүйлүүд тодорхой болно.

Тухайлбал, илүүдэл бараа, бүтээгдэхүүн гэж ярьж байна. Тийм ээ. Тэгэхэд бид хянан шалгах үйл ажиллагаа явуулж байхад ердөө ганцхан төрлийн эм нь 600 сая төгрөгийн “Tocilizumab” эм гэхэд 600 сая төгрөг худалдаж авсан. Хугацаа нь дуусчихсан. Дуусахаас өмнө түүнийг өөр өвчинд хэрэглэж болохоор байхад хэрэглээгүй байж байсан.

Тийм учраас энэ улсуудад хариуцлага тооцох асуудал дээр Т.Мөнхсайхан сайд одоо анхаарал тавьж ажиллах ёстой.

Ийм хариуцлагагүй. Өөр өвчинд хэрэглэж болохоор. Май гээд өгчхөж болно шүү дээ. Тэгэхэд чинь хээвнэг суучхаад бид дайнд хэчнээн сум хэрэглэхээ мэдэхгүй учраас илүү авчихсан юм гээд сууж байгаа.

Илүү авсан бол хугацаа нь дуусахаас өмнө бусад өвчинд зарцуулчих ёстой шүү дээ. Ийм ажлаа хий л дээ. Тийм ээ.

Тийм учраас энэ дээр би зориуд ингэж хэлмээр байна.

Миний минутыг сунгачихна. Тийм ээ.

Банктай холбоотой асуудлууд байна.

Л.Энхнасан: 1 минутыг сунгана уу.

Ж.Чинбүрэн: Одоо банкнаас авах авлагаа бодох юм бол энэ чинь бараг, би буруу тооцоолоогүй бол бараг 140, 150 тэрбум төгрөг авах гээд байгаа биз дээ.

Чингис банк, Капитал банк. Сая Ерөнхий аудитор хэлж байна шүү дээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудтай холбогдоод энэ мөнгөө буцааж ав. Үүнийг хөөцөлд.

Тийм учраас Т.Мөнхсайхан сайд миний ажиллаж байсан яамны үед гэж ярьж болохгүй. Та үүнийг хөөцөлдөх ёстой, авах ёстой.

Одоо энэ үүсээд байгаа баахан өр ширийг төлөх боломж чинь энд байна шүү дээ. Тийм. Төсвөө шийдэж чадахгүй байгаа бол. Таны хийх ёстой хамгийн гол ажил гэж би харж байна.

Зүгээр сонсож бай. Өмнөх яамны хийсэн юу учраас тэд шийднэ гэж болохгүй. Яагаад гэвэл Эрүүл мэндийн даатгалын сан таны шууд харьяалалд байгаа учраас энэ мөнгөө авч чадах юм бол энэ олон өрөө дарах боломж чинь байна л гэж ярьж байна.

Тийм учраас бид одоо энэ даатгалын гүйцэтгэлтэй холбоотой үүсээд байгаа энэ олон өр шир нь буцаагаад эрүүл мэндийн салбарын хүн эмчилж байгаа эмнэлгүүдийн дарамт болж байна.

Зарим хувийн эмнэлгүүд нь гүйцэтгэлээ 100 хувь гүйцэд аваад байдаг. Улсын эмнэлгүүд нь болохоор

гүйцэтгэлээ бүрэн гүйцэд авч чаддаггүй. Тэгээд улсын эмнэлэгт ажилладаг эмч нар нь одоо яах юм. Цалингаа дутуу аваад хувийн хэвшлийнхэн нь гүйцэт аваад байх юм уу. Тэгэхдээ бүх хувийн хэвшлийнхэн нь биш шүү. Бүгдээрээ биш.

Тийм учраас би Байнгын хорооны даргад зориуд ажлын хэсэг гаргаж.../минут дуусав/

Л.Эхнасан: Миний авсан мэдээллээр хоёр ч удаа ажлын хэсэг байгуулагдаж байсан гэж сонссон.

Би бас 2021 онд даатгалын санд төвлөрөөгүйгээс болоод ингээд 218 тэрбум төгрөгийн авлага үүссэн байна гээд.

Энэ ерөнхийдөө бас аудитын тайлан дээр ч гэсэн бичигдсэн байна лээ.

485 мянга 683 иргэнд үйлчилгээ үзүүлсний төлбөрт 157 тэрбум төгрөгийг олгоогүй өглөг үүссэн. Мөн он дамжсан 60 тэрбум төгрөг. Нийт 218 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байна гээд.

Тэгээд Сангийн яамнаас тодруулж асуумаар байна. 218 тэрбумыг энэ жилийн төсөвт тусгах уу? Яаж шийдэх юм бэ?

М.Санжаадорж дарга 5 дугаар микрофоныг нээнэ үү.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Байнгын хорооны даргын асуултад хариулъя.

Одоогийн мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хуулиар өр авлага үүсгэхийг хориглосон байдаг. Өөрөөр хэлбэл Эрүүл мэндийн даатгалын сан

дотроо тоо хэмжээгээ бууруулах уу, эсвэл тарифаа бууруулах уу, эсвэл стратегийн худалдан авалт гэж нэрлэж байгаа энэ бодлогын хүрээнд аль эмчилгээ, үйлчилгээгээ илүү зохицуулах вэ гэдэг агуулгаар ажиллаад өр авлага өсөхгүйгээр тухайн үедээ ажиллах ёстой байсан.

Гэхдээ харамсалтай нь энэ өр авлага үүссэн шалтгаан нь өөрөө КОВИД-ын нөхцөл байдалтай холбоотой болчихоод байгаа юм.

КОВИД-ын нөхцөл байдлын үед бид төсвийн тухай хууль дээр бүр тусгайлан горим гаргаад хөрөнгө оруулалт, урсгал зардлыг аль болох хэмнээд, хэмнэсэн бүх л зардлаа эрүүл мэндийн салбартаа зарцуулж байсан.

Үүнтэй холбоотойгоор бид бүгдийг зарцуулсан боловч дахиад цаана нь өр үлдчихсэн.

Энэ өр маань л одоо ингээд 2 жил дараалаад дамнаад явчхаж байгаа юм. Энэ удаагийн төсвийн тодотголоор буюу маргааш батлагдах төсвөөр бид энэ өр төлбөрөөс нийтдээ 54 орчим тэрбум төгрөгийг барагдуулах гээд ямар ч байсан төсөвт тусгасан байгаа.

Цаашдаа тодорхой хэмжээгээр төсвийг тусгаад, ингээд 2025 онд ямар ч байсан үүнийг нэг талд нь гаргах талаар ажиллаж байгаа.

Гэхдээ одоогоор Сангийн яамны хувьд төсвийн төслийг эцэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байна.

Тэгэхээр энэ бол Засгийн газраар хэлэлцэгдээд ингээд өргөн мэдүүлэх үед шийдэл нь гарах байх гэж бодож байна.

Энэ бол одоо яг КОВИД-той холбоотой асуудлууд үүсэж байгаа учраас Сангийн яамны хувьд ийм байр суурьтай байгаа.

Цаашдаа бусад эмчилгээ тусламж, үйлчилгээний хувьд яг стратегийн худалдан авалтаа яг энэ бодлогын хүрээндээ хийгээд явах ёстой гэдэг ийм л байр суурьтай байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: Манай Байнгын хорооны гишүүд ихэнх нь шинэ хүмүүс байгаа учраас саяын ярьж байгаа өрийн талаар, мөн энэ Капитрон банк, Капитал банк, Чингис банктэй холбоотой энэ асуудлуудаар Байнгын хороонд нэг бичиг, тайлбар ирүүлж өгөхийг хүсье.

Би гишүүддээ нэгдсэн нэг ойлголттой болох нь зүйтэй байх гэж бодож байна.

Ингээд асуулт, хариулт дууслаа.

Цаг нь дэгээрээ дуусчихсан байгаа. Ж.Баясгалан гишүүнд 1 минут өгчихье.

Дэгээрээ явна шүү. Манайхан бас ингээд гараа өргөөд яваад байж болохгүй. Нэг удаа ингээд тодруулга өгье.

Ж.Баясгалан: Уучлаарай. Түүрүүн гар өргөж амжаагүй.

Тэгээд хэдүүлээ ажил хийж байгаа юм чинь гоё яг шударга байя. Тэгэхгүй бол би асуулт асуусан. Хариулах хүн олдоогүй хэсэг хугацаа болсон. Түүний дараа.

Энэ чинь бид нарт өгсөн төсвийн гүйцэтгэлд аудитын тайлан дээр байгаа тоо шүү дээ. Тэгэхэд энэ тоог ингээд л нэг гөлөг төөрүүлж байгаа юм шиг л

яриад байх юм. Улсын Их Хурал дээр юм асуухаар бас байхгүй болчих юм.

Тэгэхээр тал талаас орж ирэхдээ мэдээллээ жоохон аваад орж ирж баймаар байна. Тодорхой хариулт өгч баймаар байна.

Би ерөөсөө маш олон асуулт асуусан. Хэзээ ч тодорхой хариулт авч байгаагүй. Дандаа л тойруулаад орхидог.

Хэрвээ бид энэ дотроо тодорхой хариулт авахгүй бол гадагшаагаа бид мэдээллээ яаж хүргэх юм.

Бид чинь ард түмний нэг төлөөлөл шүү дээ. Бид ард түмэн шүү дээ. Түүнээс биш тусдаа тийм субъект биш.

Тэгээд яг энэ дээр нэг тодорхой хариу хэлээд өгөөрэй. Хөгжлийн бэрхшээлтэй.../минут дуусав/

Л.Энхнасан: 1 минут нэмнэ үү.

Ж.Баясгалан: “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” гэж байгаа.

2023 онд энэ санд хэдэн төгрөг төвлөрсөн бэ? Энэ төвлөрсөн мөнгөнөөс ямар ямар төсөл, арга хэмжээнд хэдэн хувийг нь зарцуулсан бэ гэдгийг яг тов тодорхой хэлээд өгөөрэй. Баярлалаа.

Л.Энхнасан: Гишүүний асуултад хариу өгье. Хэн хариулах вэ? 7 дугаар микрофоныг нээнэ үү.

З.Энхболд: Гишүүний асуултад хариулъя.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй аж ахуйн нэгжээс орлого төвлөрүүлдэг. Энэ

орлогыг 2023 онд 3 тэрбум 436 сая 950 мянган төгрөг төвлөрүүлэхээр төсөвт төлөвлөсөн.

Үүнийг гүйцэтгэлээрээ 6 тэрбум 954 сая 971 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байгаа.

Энэ орлогыг зарцуулалтын хувьд бид бүхэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны 5 чиглэлээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой ажлын хүрээнд зарцуулдаг.

Энэ зарцуулалтыг авч үзэх юм бол өнгөрсөн жилийн хугацаанд нийтдээ 10 тэрбум 595 мянга 999 төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан байж байгаа.

Үүнийг дэлгэрэнгүй байдлаар авч үзэж танилцуулья. Үүнийг дэлгэрэнгүй байдлаар танилцуулах юм бол нэгдүгээрт, санхүүгийн дэмжлэг гэж зарцуулж байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой, жижиг бичил үйл ажиллагаа явуулахтай холбоотой санхүүгийн дэмжлэгт нь 6 тэрбум 38 сая төгрөгийг зарцуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хүрээнд бас зарцуулж байгаа. Энэ бол 159 сая төгрөг 143 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөн борлуулалтын үйл ажиллагаа буюу борлуулалтын түрээсийн хөнгөлөлтийг үзүүлэхэд зарцуулдаг. Энд 329 сая 127 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг шинээр бий болгохтой холбоотой дэмжлэг үзүүлдэг. Энд нь тусдаа 294 сая 70 мянган төгрөгтэй зарцуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой энэ ажлын хүрээнд нийтдээ 1 тэрбум 600 сая төгрөг зарцуулсан.

Л.Эхнасан: Асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Д.Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. М.Нарантуяа-Нара гишүүний микрофоныг өгнө үү.

М.Нарантуяа-Нара: Тодруулах асуудал дээр нэмэлт цаг өгөхгүй болохоор их хэцүү юм.

Нэгдүгээрт, одоо ингээд 2023 оны төсөв гээд ороод ирчихсэн байгаа шүү дээ. 2023 онд бид ингэж ингэж төсөв төсөвлөөд, ингэж гүйцэтгэлтэй хийгээд, ийм үлдэгдэл зөрүүтэй орж ирлээ гээд бид нараар батлуулах гэж байгаа биз дээ.

Бид энэ дээр одоо жишээлбэл гишүүд болгон л өөр өөрсдийн харилцан адилгүй. Тийм ээ. Ямар нэг юугаар үүнийг шалга гээд өгч байгаа биш, бүгдийнх нь онцолж байгаа асуудлууд харилцан адилгүй байгаа байх.

Тэгээд энэ хариултууд үнэхээр хангалтгүй байна. Жишээлбэл, би түрүүн юу гэж асуусан бэ гэхээр зэрэг энэ Гэр бүл, залуучууд хөгжлийн газарт төсөвлөсөн юугаар хэдэн хувьтай, ямар

үр дүнгээр хэмжээд энэ гүйцэтгэлээ дүгнээд энд оруулж ирж байгаа вэ гэсэн.

Хэдэн хүүхдэд. Дандаа бөөрөнхий хариулт өгөх юм. Жишээлбэл, 7.5 тэрбумыг 2023 онд хүүхдийн хөгжил, хүүхдийн нөхөн сэргээх, хүүхэд хамгаалах үйлчилгээнд явуулсан гээд ирж байна.

Энд хамгийн гол нь хэдэн хүүхэд хамрагдсан юм, хэдэн хүүхдийг хөгжил дэвшлээр хангахад ажилласан юм, хэдэн хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн юм, хэдэн хүүхдийг хэрхэн яаж хамгаалсан юм гэдэг энэ тоог л бид мэдмээр байна.

Дээрээс нь, 570 сая төгрөгийг гэр бүлд зарцуулсан гэж байна. Энд ямар гэр бүл, ямар асуудал судалгаагаар яаж хамрагдсан, ямар үйлчилгээ үзүүлсэн юм бэ гэдэг юмнуудыг мэдмээр байгаа байхгүй юу.

Тэгээд жишээлбэл бид нарт 2023 онд батлуулья гээд ороод ирсэн, ингэж гүйцэтгэсэн гээд ороод ирсэн байгаа нь энэ дээр ингээд дандаа зөрүүтэй.

Төрийн нарийн бичгийн дарга нь хэлэхдээ 34.3 тэрбумыг зарцуулсан. Төсөв яг ингэж явсан байгаа гээд. Энэ дээр болохоор 96 тэрбумаар орж ирчхээд, төсөв нь болохоороо 2023 оны төсөв нь ингээд зөрүүтэй. Хаана энэ зөрүү нь. Арван хэдэн тэрбумын зөрүү явагдаад байгаа байхгүй юу.

2023 оны гүйцэтгэл нь 21 тэрбум гэххээд, энд болохоороо 34.3 тэрбум явсан гээд байж байна.

Би их гайхаад байх юм. Ийм зүйлүүдийг. Эдгээр дээр яг тодорхой точный хариулт авахгүй юм бол нэг нь асуусан, нэг нь хариулсан. Тэгээд л нэг

ингэсхийгээд өнгөрчих юм бол энэ чинь ямар ач холбогдолтой хэлэлцүүлэг, хурал болоод байгаа юм бэ гэдэгт би маш их эргэлзэж байна.

Хоёрдугаар асуудал. Өчигдөр би “Эх нялхсын эрүүл мэндийн төв” дээр бага хүүхдээ эмнэлэгт өгөөд, би өөрөө нэг өдөр сахисан. Хурлаасаа чөлөө авсан.

Энэ дээр би нэг юмыг их гайхлаа. Одоо ингээд бид барилга байгууламж, энэ их засвараа харахаар бид маш их, хэдэн их наяд төгрөг энэ барилга байгууламж дээр зарцуулагдаад байдаг. Тэгсэн мөртлөө Эх нялхсын төвд одоо тэр амьсгалын замын халдварын тасаг дээр эх, хүүхэд байгаа өрөөнүүд нь бүр нэг умайсан. Бараг энгийн айлын нолийн өрөөнөөс ч жижигхэн ийм хэмжээ талбайтай юм байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр манай Монгол Улс чинь, одоо жишээлбэл хот дээр гэхэд хотын дарга маань зөвхөн бордюр дээр яаж аймаар том стандартыг хангаж жил болгон 15 сантиметр байх ёстой гээд жил болгон өөрчилж байна.

Тэгэхээр манай Эрүүл мэндийн сайдыг би бүр хөөцөлдөж байгаад энэ шинээр босох эмнэлгүүддээ, тэгээд энэ засвар үйлчилгээндээ үнэхээр эх, хүүхэд хамтдаа байгаа энэ тохиолдолд **эх, хүүхдийн өрөө тасалгааны стандарт**, метр квадратын стандарт гэж байдаг уу.

Тэр зүйлийг нь маш сайн анхаараад, бүр зүрх сэтгэлээсээ, өөрөө эхнэр, хүүхэд нь очиж тэнд байна гэж бодож байгаа юм шиг бүр ингээд ажиллаад өгөөсэй гэж их хүсэж байна шүү. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Б.Бейсен гишүүний микрофоныг өгнө үү.

Б.Бейсен: Засгийн газрын эрүүл мэндтэй холбоотой нэгдсэн тайланг танилцаад бас санаа зовж байна л даа.

“Эрүүл мэндийн даатгалын сан” нэлээн өртэй болчихсон байдаг. 217 тэрбум. Түүнээс ч нэмэгдэх хандлагатай.

Тэгэхээр энэ асуудал дээр Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын газар, тэгээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бас хамтраад дотроо шийдэлд хүрээд тэр худалдан авалт дээр нь анхаараад шийдэхгүй бол энэ том өр л дөө.

Нөгөө талаар эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээ доголдож байгаа асуудлууд байж байгаа.

Бид ноднин **“эмийн сонголт”** хийхэд Эрүүл мэндийн яам, компаниудаар бүгдээрэнгээр нь яваад нийслэлийн гааль, бүгдийг нь шалгасан юм.

Үргүй зардал ч их байгаа, бас эмийг устаж байгаа ч асуудал их байгаа. Тэнд ноднингийн юун дээр. Тэгэхэд Т.Мөнхсайхан сайд байхгүй байсан л даа.

Бид нарт тийм мэдээлэл өгсөн. 1 сая долларын **“Remdesivir”**-ийг Эрүүл мэндийн яам устгасан гээд л. Энэ үнэн үү? Аудитын газрынхнаас шалгаад зүгээр нэг дүгнэлт гаргаад өгчихдөг. Араас нь ордоггүй.

Шалгаад л хуулийн байгууллага руу шилжүүлэх асуудал байгаа шүү дээ. Жишээлбэл, **“Арбидол”** 20 тэрбум, **“Remdesivir”** 34 тэрбум гэх мэтээр бид нарт мэдээлэл өгч байсан.

Ер нь энэ эрүүл мэндийн салбарын асуудал дээр Т.Мөнхсайхан сайд маань

бас анхаарлаа хандуулъя. Эрүүл мэндийн яамныхан маань байж байна.

Үнэхээр эмийн асуудал хөдөө. Энд том дүн яриад байдаг. Бодит байдал дээр үнэтэй эм авч чадахгүй. Сум, багийн түвшинд эмийн сангийн асуудал үнэхээр хүнд байна.

Газар дээр нь яваад үзээрэй. Баг, сумын түвшинд. Асар их өндөр үнэтэй.

Гэтэл энэ дээр зүгээр төсвийн юм танилцуулаад л тэгээд өнгөрдөг. Энэ дээр ер нь дүгнэлт хийх цаг болсон.

Түрүүн Т.Мөнхсайхан сайдтай ярьсан. Дэмжсэн. Энэ асуудал дээрээ хамтраад ажиллаад асуудлын ард гарахгүй бол ер нь жилийн жилд ийм асуудал гардаг.

Тэр Эрүүл мэндийн даатгалын сангийн өрийн асуудал өнөөдөр сая “фэйс” дээр тавьж байна. Чингис хаан банк дээр 30 хэдэн тэрбум, Капитал банк дээр 70 хэдэн тэрбум гээд л.

Энэ компаниуд чинь бүгд ашигт ажиллаж байгаа мөртлөө зээлээ яагаад төлдөггүй юм. Аудитын газрынх нь, бусад хуулийн байгууллагаар яагаад шилжүүлдэггүй юм. Араас нь ороод.

Бүх аймгууд дээр **“Эм ханган нийлүүлэх төв”**, тухайн үедээ эмийн сангийн том газар, контор ажиллаж байсан шүү дээ. Зориулалтын складтай.

Үүнийг бүгдийг нь энэ Капитал банк авсан шүү дээ. Тэрийг нь буцаагаад авчхаж болдоггүй юм уу.

Одоо тэр байрыг нь өөрөө хувийн байгууллагууд руу түрээслээд, хөлслөөд сууж байгаа шүү дээ. Тэд нар чинь.

Энэ өр зээлийг яагаад манай Эрүүл мэндийн даатгалын сангийн яг өр зээл гээд бодох асуудал дээр хуулийн байгууллагуудаар аудитынхан энд шилжүүлээд, хууль хүчнийхэнтэй хамтраад, ажиллаад үүнийг дуусгахгүй бол энэ ажил хэзээ ч дуусахгүй.

Монгол Улсын эрүүл мэндийн салбарт санаа зовохгүй байгаа тийм банкууд өөрсдөө хэр ашигтай ажиллаж байгааг бид харж байгаа шүү дээ.

Тийм учраас манай Нийгмийн бодлогын Байнгын хороо энэ асуудал дээр Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын газартай хамтарч байгаад үүнийг өр зээлгүй орох асуудлаар яах.../минут дуусав/

Л.Энхнасан: Баярлалаа. Ж.Баярмаа гишүүний микрофоныг өгнө үү.

Ж.Баярмаа: Ер нь энэ гүйцэтгэлийн тайланг үзэж байхад, төсөв баталж байхад ч гэсэн бид нэг тодорхой ойлголт юу болсон бэ гэвэл маш их хэмжээний тэрбум тэрбумаар яригдахуйц хэмжээний мөнгөн дүнтэй, одоо юунд зарцуулагдсан нь тодорхойгүй, яагаад өглөг, авлага үүсчихсэн нь тодорхойгүй, хэзээ авч барагдуулах нь тодорхойгүй асар их ийм мөнгөн дүн, тоо, нэр төрөл байдаг юм байна.

Би тэгээд энэ хөрөнгө оруулалтын арга хэмжээний нэр төрлийг харж байхад, зүгээр эрүүл мэндийн салбарыг харахад нөгөө хавдрын эмнэлэг байтугай “Х” үсгээр эхэлсэн нэг ширхэг ч барилга, байгууламжийн нэр төрөл олсонгүй.

Монгол Улс чинь ерөөсөө хавдраар өвчлөгсөд, нас барагсдынхаа тоогоор дэлхий цойлж байгаа улс байж яахаараа хавдрын эмнэлгийн барилгын

асуудал энэ дотор байдаггүй юм. Энэ их тэрбум, олон их наядын хөрөнгө оруулалтын баримт бичиг дотор гэж гайхаж суулаа.

Тэгээд ер нь жишээлбэл энэ илүүдэл бараа гээд ямар ч ашиглалтгүй болчихсон, хугацаа нь дуусчихсан, тэгээд хаяж болдоггүй, авч болдоггүй асар олон тэрбумын энэ бараануудын. Жишээлбэл, эрүүл мэндийн салбарын 1.4 тэрбумын илүүдэл барааг бодоод үзэхээр жирийн иргэдийн голч цалинг 1.5 сая төгрөг гээд бодоход жилийн 18-хан сая төгрөг байна. Нэг иргэний голч цалин. Монгол Улсын.

Тэгээд энэ илүүдэл гээд авчихсан бараа 1.4 тэрбумыг жилийн орлого буюу цалинд нь хуваахаар 1.5 саяын сарын цалинтай хүний 77 жилийн голч цалинтай тэнцэх хэмжээний мөнгө байна шүү дээ.

Тэгэхээр бид нарт энэ нэг тэрбум төгрөг бол юу ч биш юм шиг сонсогддог болчихсон байна л даа.

Гэтэл үнэн хэрэгтээ энэ илүүдэл бараа гээд одоо ямар ч ашиглалтгүй болчихсон 1.4 тэрбум төгрөгийн бараа гэхэд чинь л энэ олон жилийн, 77 жилийн хүний цалингийн голчтой тэнцэх хэмжээний мөнгө юм байна шүү дээ.

Тэгэхээр одоо энэ дээр юун төлөө **“Шинэ 30 жил”** гэж манай Ерөнхий сайд томьёолж яриад байгаа.

Тэгэхээр одоо энэ өнгөрсөн 8 жил дүүрч гэхэд энэ **“шинэ 30 жил”**-ийнхээ эхлэлийг маш зөв зүй зүйтэй тавимаар байна.

Татвар төлөгчдийн зовж байж олж, түүнээсээ илүүчилж төлж байгаа энэ мөнгийг үр ашигтай зарцуулмаар байна.

Ийм үргүй зардалд ерөөсөө үрмээргүй байна.

Идэж ууж байгаа нэг хэрэг. Идэж ууж байгаа, авлига авч байгаа.

Дээрээс нь ингээд ерөөсөө үргүй зардал гаргаад баахан бараа аваад тавьчихдаг. Наад захын энэ асуудлуудаасаа бид бүрэн ангижрахгүй бол Монгол Улсын хөгжлийн талаар ярих ямар ч яриа байхгүй.

Тэгээд ер нь энэ Үндэсний аудитын газраа бид ямар статустай, ямар байгууллага болох ёстой юм гэдэг дээр ч гэсэн бодмоор юм байна.

Энэ их ажил хийгээд юм гаргаж ирээд байдаг. Хэрэгжихгүй байгаад байвал бараг энэ чинь хайран цаг хугацаа юм биш үү гэж хүртэл бодогдож байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг нээнэ үү?

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Би санал хэлэх гэсэн юм.

Засгийн газрын гүйцэтгэлийн тайлан дээрээс харж байхад төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 2023 онд 265.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гараад, 63.9 тэрбум төгрөгийн хэмнэлттэй гарчихсан байгаа юм.

Тэгээд миний санал бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хамаатай гэж ойлгох хэрэгтэй.

Энэ хэмнэлт юунаас гарчхав гээд харахаар **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”**-гаас жишээлэх юм бол 16.7 тэрбум,

Эргээд хариуцлагын асуудал яаж тооцогддог талаар мэдээлэл байхгүй. Аудит бол хөөрхөн ажлаа хийгээд гаргадаг. Эргээд энэ хэдэн хүн дээр нь яаж хариуцлага тооцогдсон тал дээр хэн ч мэдээлэлгүй хоцордог.

Нэгэнт бид энэ олон зөрчил, дутагдлыг илрүүлээд хариуцлага тооцохгүй л юм цаашаа энэ асуудал ерөөсөө хэзээ ч цэгцрэхгүй. Бид Аудитын ерөнхий газартай байгаад ч ер нь нэмэртэй юм уу, үгүй юу гэдэг л асуудал яригдана.

“Хүүхдийн төлөө сан”-гаас 8.9 тэрбум, **“Боловсролын зээлийн сан”**-гаас 6.7 тэрбум гэх мэтчилэн.

Тэгээд одоо бид орон нутагт ажиллахад үнэхээр **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”**-гаас тодорхой дэмжлэг, тусламж авах гэж хүсэлт гаргасан, **“Боловсролын зээлийн сан”**-д хамрагдах гэсэн, сургалтын төлбөрөө төлж чадахгүй байна гэсэн, хүүхэд нь өвдөж зовсон, тусламж, дэмжлэг хэрэгтэй байгаа ийм нэн хэрэгцээ шаардлагатай байгаа хүмүүсийн асуудлууд үнэхээр их байна шүү дээ.

Тэгээд яагаад бид нарын энэ төлөвлөөд зорчсон байгаа мөнгө нь хэмнэгдээд байгаа юм бэ гээд тайлбарыг нь харахаар тухайлах юм бол **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”**-гийн 16.7 тэрбум төгрөгийн хэмнэлт нь залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх зорилготой оролцоо гээд энэ төслийг боловсруулаад Засгийн газрын хуралд танилцуулахаар бэлтгэсэн боловч хуралдаанаар хэлэлцээгүй учраас гээд.

Үгүй ээ, тэгээд ийм байдлаар бид хэмнэлт хийгээд, хэмнэлт хийсэн нь сайн юм шиг байгаад байж болохгүй байх л даа.

Яагаад гэхээр эргээд энэ чинь бид Засгийн газрын бодлого, шийдвэрийг, төрийн бодлого, шийдвэрийг ард түмэнд хүргэж, амьдрал ахуйг нь сайжруулахын төлөө энэ төсөл хөтөлбөрүүдийг санаачилж, үүнд шаардагдах хөрөнгийг төлүүлчхээд, түүнийгээ яг бодит гүйцэтгэл дээр нь хэрэгтэй газар нь гаргаж чадахгүй, үр дүн гаргаж чадахгүй бол төрийн ажил хүрэх ёстой хүндээ, хүртээмж авах ёстой хүндээ хүрэхгүй л ийм нөхцөл байдал руу орчхоод байгаа юм л даа.

“Хүүхдийн төлөө сан” гээд одоо жишээлбэл 8.9 тэрбум төгрөг.

Би яаманд дараагийн тавих гээд байгаа санал бол энэ журмуудыг Та бүхэн нэг эргэж хараач ээ.

Би энэ “Хүүхдийн төлөө сан” ямар журмаар зохицуулагдаж явдаг юм гээд Засгийн газрын 2021 оны 6 сарын 23-ны 172 дугаар тогтоолоор батлагдсан журам байна л даа.

Тэгээд энэ журмаар “Хүүхдийн төлөө сан”-г нэг хэд хэдэн зүйлд зарцуулахаар л тусгасан байгаа юм.

Нэгдүгээрт нь, хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих.

Хоёрдугаарт нь, олон улсын тив, дэлхийн урлаг, соёлын тэмцээн, арга хэмжээнд амжилттай оролцсон хүүхдүүдийг шагнаж урамшуулах.

Энэ төрлийн тэмцээнд бэлдэж байгаа “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх” л гэж байгаа юм.

Гэтэл өнөөдөр бид “Хүүхдийн төлөө сан” юунд хэрэгтэй байна гэхээр

нэгдүгээрт, хүүхдийн эрүүл мэндэд хэрэгтэй байна. Эрүүл мэндийн асуудалд.

Өнөөдөр маш олон бага насны хүүхдүүд, бараг ой хүрээгүй хүүхдүүд хүртэл хавдрын өвчлөл эрсдэлтэй, энд тэндээс хандив, тусламж, дэмжлэг гуйсан маш олон хүүхдүүд байна.

Энэ хүүхдүүдэд бид нэн тэргүүнд хүүхдийг эрүүл байх асуудалд энэ “Хүүхдийн төлөө сан”-гаа зарцуулаач.

Дараа нь тэр боловсролын асуудалд, хөгжлийн асуудалд энэ асуудлаа зарцуулаач.

Түүнээс хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын асуудал нь төсөл сонгон шалгаруулалтаар шаардагдах нэг ч төсөл ирээгүй учраас энэ мөнгө хэмнэгдсэн гээд хэдүүлээ сууж баймааргүй байна.

Хүүхдэд зориулсан тэр бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтынхаа ажлыг улсын төсөвтөө тусгаад бодлогоор хийдэг болмоор байна.

Хэн нэгэн санаачилбал хүүхдийн төлөө бүтээн байгуулалт хийдэг, хэн нэгэн санаачилж төсөл орж ирэхгүй бол хүүхдийн төлөө бүтээн байгуулалт явдаггүй байж болохгүй.

Энэ бол төлөвлөлтөө бодлогын яаман дээрээ байж байх ёстой учраас.

Энэ журмаа өөрчлөөч ээ. Энэ журам дээр тодорхой асуудлуудаа амьдралд ойрхон бодитой тусгаж өгөөч ээ гэдэг хүсэлт, санал байгаа юм. 1 минутаа нэмээд авчихъя.

Дараагийн асуудал энэ **“Боловсролын зээлийн сан”**-гаас хэмнэгдээд байгаа асуудлууд болохоор

хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй чиглэлийн мэргэжлүүд дээр.

Одоо тэргүүлэх чиглэл, эрэлттэй мэргэжил дээр суралцахаар санал өгсөн хүний тоо байхгүй, тоо нь буурчихсан гээд байгаа юм.

Гэтэл өнөөдөр энэ эрэлт.../минут дуусав/

Л.Энхнасан: Үг хэлэхэд дэгээрэй минут нэмдэггүй юм билээ.

Тэгэхээр дэгээ дагаад явсан нь зүйтэй байх.

Ингээд үг хэлж дууслаа. /алх цохив/

Тэгэхээр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн

гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулна. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёрдугаар хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хурал дууссан тул хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа.

Хуралдаан 1 цаг 26 минут үргэлжилж, 14 цаг 10 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД